Российская академия наук
Институт восточных рукописей
(Азиатский Музей)

Адрес учредителя: 191181,
г. Санкт-Петербург,
Дворцовая наб., д. 18.

Адрес редакции: 191181,
г. Санкт-Петербург,
Дворцовая наб., д. 18.

Адрес издателя: 191181,
Санкт-Петербург,
Дворцовая наб., д. 18.

Тел.: +7 (812) 315-87-28
http://orientalstudies.ru
mongolica@orientalstudies.ru
kulgan@inbox.ru
dnosov@mail.ru

Регистрационный номер
свидетельства о регистрации
средства массовой информации
ПИ No ФС77-79202
от 22 сентября 2020 г.

MONGOLICA

Санкт-Петербургский журнал монголоведных исследований

Том XXVIII • 2025 • № 4

Выходит 4 раза в год
Издается с 1986 г.
Учредитель: ФГБУН
Институт восточных рукописей РАН

Редакционная коллегия:

И. В. Кульганек, *главный редактор, доктор филологических наук (Россия)*
Д. А. Носов, *секретарь редколлегии, кандидат филологических наук (Россия)*
М. А. Козинцев, *помощник секретаря, кандидат исторических наук (Россия)*

Г. Билгуудэй, *доктор филологических наук (Монголия)*
А. Бирталан, *доктор наук (Венгрия)*
Р. М. Валеев, *доктор исторических наук (Россия)*
Л. С. Дампилова, *доктор филологических наук (Россия)*
И. В. Зайцев, *доктор исторических наук, профессор РАН (Россия)*
Ж. Легран, *доктор наук, профессор (Франция)*
В. Капишовска, *доктор наук (Чехия)*
Э. Мунхцэцэг, *кандидат филологических наук (Монголия)*
С. Л. Невелева, *доктор филологических наук (Россия)*
К. В. Орлова, *доктор исторических наук (Россия)*
М. П. Петрова, *кандидат филологических наук (Россия)*
Р. Поп, *доктор наук (Румыния)*
Ц. Саранцацрал, *доктор филологических наук (Монголия)*
Т. Д. Скрынникова, *доктор исторических наук, профессор (Россия)*
С. Чулуун, *академик МАН (Монголия)*
Е. Э. Хабунова, *доктор филологических наук (Россия)*
Н. Хишигт, *кандидат исторических наук (Монголия)*
Н. С. Яхонтова, *кандидат филологических наук (Россия)*

Оригинал-макет – М. В. Алексеева
Литературные редакторы и корректоры – Д. А. Носов, И. В. Кульганек
Технический редактор – М. А. Козинцев
Подписано в печать 15.12.2025
Формат 60×90 $^{1}/_{8}$. Объем 9 печ. л. Заказ №
Тираж 300 экз.
Отпечатано в типографии ООО «Литография Принт».
Адрес типографии: 191119, Санкт-Петербург, ул. Днепропетровская, д. 8, лит. А, офис 14.
e-mail: info@litobook.ru

ISSN 2311-5939

DOI 10.48612/IVRRAN/zk3g-736z-g9nu

12+

© Институт восточных рукописей РАН (Азиатский Музей), 2025
© Коллектив авторов, 2025

В НОМЕРЕ:

ФИЛОЛОГИЯ

Б. Мөнх-Эрдэнэ. Д. Цоодолын уран бүтээлийн өв, туурвилын онцлог 5

М. В. Фионин. Маргарита Михайловна Елизарова как переводчик Апокрифа завещание Авраама: вклад в изучение древнееврейских текстов..... 13

С. Энхжаргал. Монгол хэлний хэлцэд оршихуйн зүйрлэл илрэх нь 25

СМЕЖНЫЕ ДИСЦИПЛИНЫ

И. А. Алимов. «Дун цзин мэн хуа лу»: великие внутренние [покои] 33

К. А. Бекетов, Н. К. Бекетова, Ли Чжуанчжи. Анализ поступательного развития российско-китайского сотрудничества в художественной сфере 41

Е. М. Белкина. Еврейская палеография в Иране: от первых документов до XIV в. 53

НАУЧНАЯ ЖИЗНЬ

Л. С. Дампилова. III Сибирский форум фольклористов. Международная научная конференция (Новосибирск, 16–20 июня 2025 г.) 64

Т. В. Ермакова. Конференция «Актуальные проблемы буддологических и индологических исследований–19» (Санкт-Петербург, 14 июля 2025 г.) 67

Р. В. Ивлева. Международный симпозиум по монголоведению 2025 (Китай, Хух-Хото, 20–21 августа 2025 г.) 70

Н. В. Ямпольская. Выставка «Калмыцкие буддийские шедевры из музеев Санкт-Петербурга» в Национальном музее республики Калмыкия им. Н. Н. Пальмова (Элиста, 25 сентября — 16 ноября 2025 г.) 76

РЕЦЕНЗИИ

Е. В. Асалханова. *Рец. на*: Батырева С. Г. Живопись во времени и пространстве культуры. К 100-Летию Народного Художника РСФСР Гаря Рокчинского (1923–1993) 80

М. П. Петрова. *Рец. на*: Эх орон-Их Ялалт. Родина-Великая Победа 86

RUSSIAN ACADEMY OF SCIENCES
Institute of Oriental Manuscripts
(Asiatic Museum)

MONGOLICA

Saint Petersburg journal for Mongolian studies

Vol. XXVIII • 2025 • No. 4

The journal is published four times a year.
Published since 1986
Founder: Federal State Institution of Science
Institute of Oriental Manuscripts of the Russian Academy
of Sciences

Editorial board:

I. V. Kulganek — *editor-in-chief, Dr. Sci. (Philology), Russian Federation*
D. A. Nosov — *secretary, Cand. Sci. (Philology), Russian Federation*
M. A. Kozintcev — *assistant secretary, Cand. Sci. (History), Russian Federation*

G. Bilguudei. *Dr. Sci. (Philology), Mongolia*
A. Birtalan. *Ph. D., Hungary*
S. Chuluun. *Academician of the Mongolian Academy of Sciences, Mongolia*
L. S. Dampilova. *Dr. Sci. (Philology), Russian Federation*
J. Legrand. *Dr. Sci., Professor, France*
V. Kapishovska. *Ph. D., Czech Republic*
E. E. Khabunova, *Dr. Sci. (Philology), Russian Federation*
N. Khishigt. *Ph. D. (History), Mongolia*
E. Munkhtsetseg. *Cand. Sci. (Philology), Mongolia*
S. L. Neveleva. *Dr. Sci. (Philology), Russian Federation*
K. V. Orlova. *Dr. Sci. (History), Russian Federation*
M. P. Petrova. *Ph. D. (Philology), Russian Federation*
R. Pop. *Ph. D., Romania*
Ts. Sarantsatsral. *Dr. Sci. (Philology) Mongolia*
T. D. Skrynnikova. *Dr. Sci. (History), Russian Federation*
R. M. Valeev. *Dr. Sci. (History), Russian Federation*
N. S. Yakhontova. *Cand. Sci. (Philology), Russian Federation*
I. V. Zaytsev. *Dr. Sci. (History), Professor of the Russian Academy of Sciences, Russian Federation*

191181. Russian Federation
Saint Petersburg,
Dvortsovaya Emb., 18

Phone: +7 (812) 315-87-28
http://orientalstudies.ru
mongolica@orientalstudies.ru
kulgan@inbox.ru
dnosov@mail.ru

ISSN 2311-5939

DOI 10.48612/IVRRAN/zk3g-736z-g9nu

© Institute of Oriental Manuscripts RAS
(Asiatic Museum), 2025
© Group of authors, 2025

IN THIS ISSUE:

PHILOLOGY

Batmunkh Munkh-Erdene. The Artistic Heritage and Stylistic Features of D. Tsoodol's Works 5

Maksim V. Fionin. Margarita Mikhailovna Elizarova as a Translator of the Apocryphal "Testament of Abraham": On Her Contribution to the Study of Ancient Hebrew Texts 13

Sanjperleegiin Enkhjargal. The Manifestation of Ontological Metaphor in Mongolian Idioms..... 25

RELATED DISCIPLINES

Igor A. Alimov. «Dong Jing Meng Hua Lu»: Great Inner [Chambers] 33

Konstantin A. Beketov, Natalya K. Beketova, Li Zhuangzhi. Tanalysis of the Progressive Development of Russian-Chinese Cooperation in the Field of Fine Arts 41

Ekaterina M. Belkina. Hebrew Palaeography in Iran: From Early Documents to the Manuscripts of the 14th Century 53

ACADEMIC LIFE

Lyudmila S. Dampilova. The 3rd Siberian Forum of Folklore Researchers. International Scientific Conference (Novosibirsk, June 16–20, 2025) 64

Tatiana V. Ermakova. The 19th Conference "Current Issues of Bbuddhological and Indological Studies" (St. Petersburg, July 14, 2025) 67

Regina V. Ivleva. The International Symposium on Mongolian Studies 2025 (Hohhot, China, August 20–21, 2025) 70

Natalia V. Yampolskaya. "Kalmyk Buddhist Masterpieces From The Museums of St. Petersburg" — an Exhibition at the National Museum of the Republic of Kalmykia (Elista, September 25 — November 16, 2025)..... 76

BOOK REVIEWS

Ekaterina V. Asankhanova. *Rev. of the book*: Batyreva, Svetlana. G. Painting in Time and Space of Culture. To the 100th Birthday Anniversary of the People's Artist of the Russian Soviet Federative Socialist Republic Garya Rokchinsky (1923–1993)..... 80

Maria P. Petrova. *Rev. of the book*: Motherland — Great Victory..... 86

УДК 81.255
DOI 10.48612/IVRRAN/8zmx-r91r-g8mr

Б. Мөнх-Эрдэнэ
Монгол Улсын ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн

Д. ЦООДОЛЫН УРАН БҮТЭЭЛИЙН ӨВ, ТУУРВИЛЫН ОНЦЛОГ

Тус өгүүлэлд монголын орчин үеийн уран зохиолын томоохон төлөөлөгч Монгол Улсын төрийн соёрхолт, Ардын уран зохиолч, Соёлын гавьяат зүтгэлтэн Д. Цоодолын уран бүтээлийн өв, туурвил зүйн арга барилын талаар өгүүлжээ. Чингэхдээ түүний яруу найргийн бүтэц, төрөл зүйлийн онцлог, дуулийн төрөл зүйлд оруулсан хувь нэмэр, хүүрнэл зохиолынх нь зарим онцлогыг авч үзжээ. Д. Цоодол нь утга зохиолын яруу найраг, хүүрнэл зохиол, орчуулга, нийтлэл, эсээ зэрэг бараг бүхий л төрөл зүйлээр жигд ажиллаж томоохон өвийг бүтээсэн уран бүтээлч юм. Монгол ахуй, түүний сайхныг сэрж мэдэрсэн уран зураглал, уран санаа, гоо сайхны нээлтэд хүргэсэн дүрслэл, хүн байгалийн шүтэлцээт хүйн холбоо, түүнээ хүний сэтгэлийн олон өнгө аясад нээн үзүүлэхэд чиглэсэн олон зохиол бүтээлийг Д. Цоодол бичжээ. Тэр дундаа монголын орчин үеийн уран зохиолын санд цөөнгүй дууль бичиж өргөсөн гавьяатай билээ. Эл өгүүлэлд Д. Цоодолын хүүрнэл зохиолын туурвил зүйн бусдаас ялгарах онцлог шинж, ур чадварыг тодруулахыг зорьсон байна. Түүнчлэн Д. Цоодолын бүтээл амилах орчны тухай өгүүлж, хүүрнэх арга барилынх нь тухай бичсэн байна.

Түлхүүр үг: Д. Цоодол, туурвил зүй, яруу найраг, хүүрнэл зохиол.

Зохиогчийн тухай: Батмөнхийн Мөнх-Эрдэнэ, Монгол Улсын ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн Утга зохиол судлалын салбарын эрдэм шинжилгээний ажилтан (Улаанбаатар, Монгол Улс) (munkherdene_b@mas.ac.mn).

© Мөнх-Эрдэнэ Б., 2025

Аливаа сонгодог зохиолч нь өөрийн гэсэн туурвил зүйн арга барил, “өв” (legacy)-ийг бүтээж чадсанаараа бусдаас ялгарч байдаг аж. Тиймээс тэрхүү зохиолчийн уран сайхны өв, туурвил зүйг судлан шинжилж, уламжлал шинэчлэлийн холбоог нь тодруулан, туурвил зүйн арга туршлагыг нь танин мэдэх нь уран зохиол судлал шинжлэлийн тулгар асуудлын нэг болдог байна. Энэ үүднээс бид монголын орчин үеийн уран зохиолын томоохон төлөөлөгч Д. Цоодолын уран бүтээлийн өв, туурвилыг судлахыг зорьсон болно. Д. Цоодол 1982 онд “Тогоруун цувуу” шүлгийн номоороо МЗЭ-ийн шагнал, 1996 онд “Нутгийн зургаан өнгө”, “Он жил”, “Тэнэг”, “Харамчийнхан дуулиараа Төрийн шагнал, 1984 онд “Нэр нь тодроогүй баатрууд”, 1993 онд “Миний муу сайн найз нар”, 1997 онд “Хуучин дэр модны дууль шүлгээрээ “Болор цом”-ын тэргүүн шагнал, 2005 онд Соёлын гавьяат зүтгэлтэн, 2009 онд Ардын уран зохиолч цол хүртжээ.

Д. Цоодол нь утга зохиолын яруу найраг, хүүрнэл зохиол, орчуулга, нийтлэл, эсээ зэрэг бараг бүхий л төрөл зүйлээр жигд ажиллаж томоохон өвийг бүтээсэн уран бүтээлч юм. Түүний уран зохиолын олон талт бүтээл туурвилаас “Харамчийнхан”, “Тэнэг”, “Миний муу сайн найз нар”, “Хуучин дэр модны дууль” тэргүүт олон шүлэг, дууль нь монголын ард түмний зүрх сэтгэлд хоногшсон нандин бүтээл болсны дээр иргэний утга уянгын яруу найргийн гарамгай сайн жишээ болсон, уран сайхны туурвил зүйн сэтгэлгээний үнэт өв болсон бүтээл билээ. Тэр бээр монгол яруу найргийн дотоод зүйлийн хөгжилд, ялангуяа орчин үеийн монгол дуулийн төрлийг хөгжүүлэх, төлөвшүүлэхэд үнэт хувь нэмэр оруулсан байна. Түүний туурвил зүйн сэтгэлгээний гүнзгийрэл далайц, уран сайхны шинэчлэл хийсэн арга барил, бодрол бясалгал, гүн ухааных нь үзэл баримтлал, улмаар монголын орчин үеийн уран зохиолын хөгжилд

оруулсан хувь нэмрийг тодруулах нь зүй ёсны хэрэг юм. Түүний шүлэг найраглал нь орос, англи, араб, герман, польш, япон зэрэг хэлэнд орчуулагдан гадаадын уншигчдын сонирхлыг татаж зарим шилдэг бүтээл нь ерөнхий боловсролын дунд сургуулийн сурах бичигт орж Монголын орчин үеийн уран зохиолын түүх болон судлал шүүмжлэлийн олон номд өндөр үнэлэгдсэн байна.

Д. Цоодолын яруу найргийн туурвил зүйн онцлог

Д. Цоодол яруу найргийн төрлөөр "Нутгийн зургаан өнгө" (1970), "Саруул талын ногоо" (1975), "Алаглан харагдах уулс" (1980), "Тогоруун цуваа" (1980), "Миний өв хөрөнгө" (1988), "Бодох цаг" (1990), "Хэнэггүй эрийн дууль" (1996), "Миний муу сайн найз нар" (1999), "Сөгдөж айлтгая" (2001), "Сарваа цуцахын талаас" (2008), "Харамчийнхан": тэргүүт дуулиуд" (2024), "Бараа бараандаа хорвоо" (2024) зэрэг түүвэр гаргажээ. Д. Цоодол нь яруу найргийн төрөл зүйлийн хувьд уянгын шүлэг, дууны шүлэг, дууль, найраглал, гурван мөрт, дөрөвт, "ээмэг үгс"[1], наймт, арван дөрөвт зэрэг богино шүлэг, өгүүлсэн шүлэг зэрэг олон төрөл зүйлээр бичжээ. Тэр бээр аялгуу сайхан монгол хэлний уран яруу хэрэглүүр, далай баян үгсийн санг зохист газар нь эрдэнийн чулуу, шүр, сувд адил шигтгэн, яруу тансаг хэл найруулгаар шүлэг найргаа туурвих талаараа онцгой уран бүтээлч билээ. "*Цоодолын шүлэг найраглал монгол хийцтэй, тансаг, торгон болой*", "*Түүний шүлэг найраглалаас найрагчийн үгийн нүдийг олох, сонгохдоо гарамгай, төрөлх монгол хэлээ сайн мэддэг нь алхам бүрд нь харагдана. Шүлэг зохиолыг нь монгол, тансаг, торгон болгодог нэг энгийн юм шиг атлаа "ид шид" нь энэ болов уу*" [Ганбат 2019. Х. 312].

Бидний ажигласнаар Д. Цоодолын шүлгүүд монгол яруу найргийн уугуул шинж чанарыг гүн гүнзгий хадгалсан бүтэцтэй байна. "*Д. Цоодолын шүлэг найраг уламжлалт монгол бичлэгтэй. Ер нь монгол шүлэгтэй. Ардын аман зохиолын тансаг сайхнаас бас гарвальтай. Өөрөөр хэлбэл, монгол яруу найрагчийн төрөлх мэнгэтэй. Сэтгэлгээний хувьд бол чөлөөтэй. Дорно дахины хийгээд европ зүгийн сэтгэлгээ аль аль нь тун сайхнаар эвцэлдсэн байдаг*" [Ганбат 2019. Х. 300]. Түүний шүлгийн мөрүүд хэм тэгш зарчимтай тул үгс төгс зохицолтой, уянгалаг сонсголонт шинжтэй байна. "*Монгол шүлэг уугуул байгуулллаараа өрнөдийн шүлгээс эрс ялгаатай тооны бус чанарын шүлэг билээ. Тэр үүднээсээ толгой холбоц, тэргүүлэх үүрэгтэй, дунд болоод сүүл холбоц дагалдах шинжтэй, мөр хоорондын үг, үеийн тоо ижил байхыг чухалчилдаг сонсголонт айзам хэмнэлт шүлэг юм*" [Галбаяр 2017. Х. 5]. Монгол шүлгийн энэ шинж нь Д. Цоодолын бүтээлд гүнзгий хадгалагдан үлдсэн байна. Тодруулбал, түүний шүлгүүдийн мөрөн дэх үгийн тоо тэнцүү, хэмжээ хэмнэл жигд, хос мөр өрөгдөх зарчмаар бичигдсэн онцлогтой байна. Тухайлбал, нэргүй нэгэн шүлэгт нь:

"*Дагжтлаа норсон модноос хондон навчис*
Далавч нь сэвтсэн эрвээхий шиг унаж байна
Дааж ядсан манан дороо Богд уул
"Дахиад л өвөл" хэмээн барайж байна
Халуун орныг тэмцэн үүлэн цаана
Хаа ч юм бэ, холд тогоруу дуугарна
Гадуур минь урсдаг горхи мөсөнд хүлээстэй
Газар биш би өөрөө гандсан мэт уйтай..."

гэх мэтээр мөр бүр дэх үгийн тоог 5–6 үгээр тэнцүүлж, толгой, сүүл холбоцоор жигд хэмнэл үүсгэсэн байна. Энэ мэт жишээг түүний олон шүлгээс харж болно. Түүнчлэн хос мөр нь өрөгдөх зарчмаар

"*Нүд чих минь-сүмийн цонх хаалга*
Нүгэлтэн, буянтан цөмөөр түүгээр орж гарна
Сэтгэл минь сүмдээ мандаасан зул
Сэргэж, унтарч бас дахин гэрэлтнэм ээ"

хэмээн шүлэглэсэн байдаг. Тэр бээр монгол шүлэгт ялангуяа хуучны шүлгийн бичлэгт өргөн дэлгэр байсан зургаан үгтэй урт мөрөөр зургаан шад бүхий бадгаар шүлгийг хайрцаглан бичих хэлбэрийг голлож, үүнийгээ ард

[1] Зохиолч "Бараа бараандаа хорвоо" (2024) номдоо дөрвөн мөрт шүлгүүдээ ийн нэрлэсэн байна. Тодруулбал, "Саяхан би нэгэн бүлэг дөрвөн мөрт олон шүлэг бичив. Шүлгүүдээ Ээмэг үгс хэмээн нэрлэж эл шинэ түүвэртээ ээмэг болгон зүүж өгөв" хэмээжээ. Энэ бүлэг шүлэг нь "Үг зохиол"-ын төрөл зүйл шиг хүн ба адгуус амьтан, амьгүй эд юмсын хоорондох яриа, мэтгэлцээний журмаар ертөнцийн аливаа үзэгдэл, эд юмсын мөн чанар, жам ёсыг нээн харуулахыг зорьсон мэт байна.

түмний дунд хэвшсэн тогтсон зүйрлэл бүхий айзамтай бичсэн нь нэлээд өвөрмөц байна. Шүлгийн санаанд тохируулан монгол хүний хэл сэтгэхүйд хэвшсэн тогтмол чимэг, тодотгол, зүйрлэл, адилтгалыг өргөнөөр ашиглаж, монгол хүний байгаль орчиндоо хандах онцлогийг тусгахын хамт тэрхүү өвөрмөц тусгалыг өөрийн санаагаар баяжуулахдаа зөвөөр жолоодож зохистой хэрэглэсэн нь шүлгийн урлах чадварт сайн нөлөө үзүүлжээ.

Түүний шүлэг нь ямар нэгэн хөгжмийг бий болгож, уянгын байдал, дуун бүтцээр бүрдсэн байдаг. Мөрүүд нь тогтсон хэмжээнд тохирсон байдалтай бөгөөд энэ нь уншихад хөгжим шиг мэдрэмж төрүүлдэг онцлогтой. Шүлэгт нь монгол шүлгийн уламжлалт шинж чанарууд илэрхий харагдана. Д. Цоодолын яруу найргийн туурвилын онцлог нь яруу найргийг амьдралтай хамгийн ойр хэлээр бичдэгт оршино. Шүлэгийнх нь мөр бүр нь ихэвчлэн 6–10 үгтэй, уншигдахдаа хурдан, хэмнэлтэй, аман ярианы аястай. Нэг мөр — нэг санаа гэсэн бүтэцтэй, мөр хоорондын уялдаа, хөг аясыг алдагдуулалгүй уламжлалт монгол уран цэцэн хэллэгээр холбож өгсөн байдаг онцлогтой.

Монгол дуулийн хөгжилд Д. Цоодолын оруулсан хувь нэмэр

"*1950-аад он монголын утга зохиолын түүхийн чухал үе шат байлаа. Энэ үеэр хөгжингүй утга зохиолд байдаг гол төрөл зүйлүүд манай шинэ уран зохиолд бүрэлдэн тогтсон үе мөн. ...зохиолчид гадаад уран зохиолын онол, боловсрол эзэмшиж, дэлхийн уран зохиолоос орчуулан нийтлэх ажил урд үзэгдээгүй ихээр өрнөн, олон талын харилцаа өргөжсөн нь манай уран зохиолд төрөл зүйлийн баяжилт, дүр дүрслэлийн шинэ эрэлхийлэл арга хэлбэрийг шинэчлэх үзэл санаа гүнзгийрчээ*" [Галбаатар, 1994. Х. 44]. Ийнхүү манай яруу найрагт дууль, сонет, романс, ронда зэрэг европ ба дэлхийн шүлгийн өвөрмөц төрөл зүйлийг эзэмших, үндэсний яруу найрагт хэлбэршүүлэн авах оролдлогууд үндсэндээ 1950–1960 онд эрчимжсэн байна. Энэ үед монгол дууль төрөл зүйлийнхээ шинжийг олж, эрчимтэй хөгжиж, дууль бичлэгийн анхны бие даасан бүтээлүүд гарчээ. Ч. Лхамсүрэн, Ч. Чимид, Б. Явуухулангийн дуулиудыг залгаж монгол дуулийн хөгжилд томоохон хувь нэмэр оруулсан уран бүтээлч бол Д. Цоодол юм. Тэр бээр энэ төрлөөр 80 орчим бүтээл туурвисан байна. Бүрэнгийн ухаа толгод, нутгийн зон олон бол Дөнгөтийн Цоодолын бүтээл амилах орчин юм. Түүний эх нутаг, газар шороо, хүний өөрийн ах дүүсээ хайрлан энэрэх, түүх, соёлоо үлдээн өвлүүлэх, ёсорхон хүндэтгэх үзэл санаа олон зохиол бүтээлд нь тусгалаа олсон байдаг. Ялангуяа дуулиудаас нь Бүрэн сумынхны амьдрал, ахуй байдал, хүн ардын жаргал зовлон, хэв заншил тод харагддаг. Тиймээс түүний дуулиуд дахь дүр дүрслэл, ахуй дүр нь зохиолчийн амьдрал ахуйд тохиолдсон явдлаас эх үндэстэй бөгөөд бодит байдлын уран сайханж сан тусгал гэж хэлж болно. Тухайлбал, "Талын булаг", "Сарваа цуцахын тал" — "Жарангийн хөндий" зэрэг зохиолчийн төрөлх нутгийн газар усны нэр, хүн ардын түүх олонтоо дурдагддаг.

Дууль (англ. Ballad, ор. Баллада) нь хурц зөрчил тэмцэл бүхий өгүүлэмж, үйл хэрэг явдлыг үзүүлсэн, бадрангуй эмгэнэл, үзэл санааны баатарлаг ялалтыг дэвшүүлсэн, сэтгэл зүйн гүн гүнзгий агуулгыг илэрхийлсэн уянга-туульсын зохиол юм. Дууль нь түүхэн зайлшгүй шаардлага ба түүнийг биелүүлэх бололцоогүй нөхцөл хоёрын хоорондын зөрчилд суурилдаг ажээ. Тиймээс дуулийн зөрчил нь нийгмийн чанартай томоохон үзэгдлийг илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл хүн, нийгэм, хамт олон, эх орныхоо сайн сайхны төлөө эр зоригтой баатарлаг хүмүүсээс явуулж буй тэмцэл янз бүрийн хэлбэрээр түүхэн зайлшгүй шаардлагаар өрнөж, тэр нь биелэх бололцоогүй нөхцөлд ялагдал хүлээх ба түүнээс нэвтрэн гарах санаа нь баатарлаг, бадрангуй шинжтэй байдаг гэсэн үг юм. Дуульд дараах хэдэн гол шинжүүд байдаг байна.

1. Үйл явдлын байгууламж хураангуй зангилаа, өрнөл, тайлал гол үүрэгтэй бөгөөд эхлэл зангилаа, өрнөл туйл, тайлал төгсгөл гэсэн нийлэг бүтэцтэй байна.

2. Үйл явдал нь хурц зөрчилтэй, огцом өрнөлтэй бөгөөд ихэвчлэн эерэг баатрын үхэл (хохирлоор) төгсдөг.

3. Дуулийн агуулга эмгэнэлт, баатарлагийн харьцаанд суурилдаг

4. Дууль нь үйл явдлын эцэс туйлыг сонгон өгүүлнэ

5. Дуулийн агуулга нууцлаг бөгөөд уншигчийн сэтгэл оюунд тайлагдана.

6. Дууль өнгөрсөн хэрэг явдлыг өгүүлэгчийн хүүрнэлээр сэргээн өгүүлдэг. Их төлөв болсон явдал хууч яриа домгийн үндэстэй байна. Д. Цоодол нь дуулиуддаа эдгээр шинжүүдийг зохистой хослуулсан байдаг учраас дуулийн өвөрмөц хэлбэршлийг бүтээсэн байна. Тийм ч учраас судлаачид түүнийг "Дуулийн урлаач", "Дуулийн эцэг", "Дуулийн мастер" гэх зэргээр өндрөөр үнэлсэн байна. Тухайлбал, Судлаач Х. Сампилдэндэв: "...*Д. Цоодол манай зохиолчдын төдий л бичээгүй дуулийн төрлөөр "Хүн оготно", "Тэнэг", "Тайж", "Панзчин", "Ноорхой", "Харамчийн дууль", "Ороо Рэнцэн" зэрэг олон бүтээл туурвисан нь эл шинэ төрөл зүйлийг эзэмшин эх утга зохиолдоо идээшүүлэх талаар хийсэн амжилттай эрлийн нь үр дүн, монголын утга зохиолын хувьд олз болсон"* [Цоодол, 2019. Х. 296] хэмээн үнэлсэн бол "Монголын орчин үеийн уран зохиолын түүх"-д: "*Дуулийн төрөл зүйлийг монголын яруу найрагт төлөвшин хөгжихөд яруу найрагч Д. Цоодолын дуулиуд тодорхой хувь нэмэр оруулсан байна. Д. Цоодолын дууль нь хорвоогийн амьдралыг сэтгэлдээ бясалгаж, энгийн болоод ойлгомжтой, даацтай, уран агаад санаа алдуулам уянгатайгаар учирласан гүн ухаан шингэсэн байдгаараа онцлог*" [МОҮУЗТ-IV 2014. Х. 86] гэж тэмдэглэжээ.

Д. Цоодолын дуулиудад монгол хүний мөн чанар, амьдрал ахуй, нийгэм, сэтгэхүйн онцлог, ертөнцийг үзэх үзэл төсөөлөл, ёс суртахуун, хайр дурлал, өрөвч нинжин сэтгэл, хүнлэг чанар, оршихуйн мөн чанар зэрэг монголчуудын төдийгүй хүн төрөлхтний мөнхийн үнэт зүйлс хадгалагдаж байна. Тухайлбал, эх орон, тусгаар тогтнолоо хадгалан хамгаалах, байгаль дэлхийгээ хайрлах үзэл зэрэг үнэт зүйлсийг Д. Цоодолын дуулиас харж болно. Тухайлбал, эх орон тусгаар тогтнолын үнэ цэний тухай "Харамчийнхан", "Панзчин" дуульд төрж өссөн нутаг усаа эрхэмлэн хайрлаж буйг дүрсэлжээ. Эл дуульдаа зохиолч үнэ цэнтэй бүхнээ зарж үрдэг олхио муутай хүний дотоод мөн чанарт ч эх орон, нутаг усаа гэсэн сэтгэл оршиж байдгийг, энэ нь хүнд юунаас ч эрхэм үнэт зүйл болохыг харуулжээ. "Монгол дуулийг дагнан судалсан судлаач Д. Галбаатар "*Д. Цоодолын 1980–1990-ээд оны дуулиуд эгэл хүний агуу сайхан сэтгэл, нуугдмал их хүч зориг, хэрэгтэй цагт илрэн гарч олон түмний тусын тулд амь насаа зориулсан гайхамшигт хүмүүсийн тухай өгүүлж байна. "Мартамхайн дууль" (1987), "Тэнэг" (1990) зэрэг нутаг нугадаа нэр хоч зүүсэн бор баарагхан хүмүүсийн тухай дууль энэ төрөл зүйлийн хөгжилд шинэ эрэл болжээ. Энэ мэтээр үхлийн хязгаарыг давсан хайр сэтгэлийн эмгэнэлт түүх эзэн нь үрэгдэж үгүй болсон ч гайхамшигт зориг, сэтгэлийн тэнхээ өндөр ёс суртахуун, өөдрөг үзэл, шулуун шударга үзэл бодол нь хүмүүс, ард олны санаа сэтгэлийг мохоодоггүй бөгөөд харин ч баярлуулан бахархуулж, сэтгэлийн зориг хүчийг нь сэлбэн тэтгэж байдаг жамтай аж"* [Галбаатар, 1994. Х. 82] хэмээсэн бол Д. Сумъяа "Монголын орчин үеийн яруу найраг" номдоо: *Д. Цоодол монгол найргийн уран тансаг, цэцэн цэлмэг шүлэглэлийн уламжлалыг өрнө зүгийн сонгодог реалист найргийн сэтгэлгээтэй хослуулж эрин цагийнхаа тухай эргэцүүллээ уран тод дүрслэлд шингээсэн олон шилдэг дууль бичив. Д. Цоодолын эгэл жирийн монгол хүний дүрийг бүтээсэн олон дууль нь монголын яруу найрагт төрөл зүйлийн хувьд төдийгүй, яруу найргийн уран дүр бүтээхэд ихээхэн хувь нэмэр болов*" [Сумъяа, 2009. Х. 77–78] хэмээсэн байна.

Урлаг уран зохиолын туйлын шинж, гол зорилго бол уран сайхны үлэмж төгс (хэв шинжит) дүр бүтээх явдал юм. Тийм ч учраас уран сайхны дүрийн тухай ойлголт уран зохиолын онолын сэтгэлгээнд голлох байр суурь эзэлж, түүнийхээ хэрээр төдий чинээ маргаан дэгдээсээр иржээ. Д. Цоодолын яруу найраг болоод дуулийн бас нэг ололттой зүйл нь орчин үеийн яруу найрагт олон сайхан шилдэг уран дүр урлан бүтээсэн явдал болно. "*Цоодол найрагчийн бүлэг дуулиудаас л нэн шинэ үеийн уншигчид маань хаа ч хөдөө, хотын эгэл жирийн эр хар хүмүүсийн өнгө будаггүй үнэн цагаан дүрүүдийг олж харж, тэдгээрийн тэр гундашгүй ариухан зан авир, гуташгүй ариухан ёс зүйг ард түмнийхээ салшгүй нэгэн шалгуурын нуугдмал мөн чанар гэдгийг ухааран тунгааж, уламжлан залгуулах болсон билээ. Ийм лут бүтээлүүдийнх нь тоонд "Миний муусайн найз*

нар", "Харамчийнхны дууль", "Уужуу Дондог", "Буруу Довдон, "Хуучин дэр модны дууль"-аас аваад ямар ч хэнэггүй хүн өндөсхийтэл босмоор, нэгийг бодуулж, хоёрыг нуумаар цэцэн мэргэн дүгнэлтүүдээр халгиж, цалгиад, бүүр нэг цээжний мухар руу хайр урсгаад явчихдаг юм. Нутаг орондоо гайхалтай нарийнаа дуудуулдаг атлаа, эх орныхоо тусгаар тогтнолын төлөө алтан амиа тоох ч үгүй тавиад туучихдаг эр хар хүн байдгийг хэн бүхэн мэдэх, тэр нь ч ерийн л нэг өдөр тутмын амьдралын салшгүй нэгэн дүр зураг байх боловч, тийм эрхэмбээрүүдийг Цоодол абугай л анх уран сайхны сонгодог дүр болгон алдаршуулж чадсанаараа Монголын яруу найрагт яндашгүй дүрийн боть болгон мөнхөлж чадсан юм" [Нэргүй, 2021. Х. 9]. Үүгээрээ тэр бээр бодит хүмүүсээс эх аван уран сайхны уран дүр хэрхэн сайн бүтээхийн үлгэр болсон юм. Үүнд: "Харамчийнхан", "Тэнэг", "Хадаг Дэжид", "Буруу Довдон", "Таван тэмээт", "Уужуу Дондог", "Сааргай", "Элчин Самбуу" зэрэг шүлэг дуулиудынх нь олон дүрийг нэрлэж болно. Эдгээр дүрээс монгол хүний эрхэмлэн дээдлэх үнэт зүйлс, нандин чанарууд тодрон харагддаг юм. Тодруулбал, "Тэнэг" дуульд:

"Сум орондоо инээд доог болсон
"Суут" тэнэг манай нутагт байх,
Хүй цөглөх багадаа авсан нэрийг нь мартаж
Хүмүүс, зүгээр л Тэнэг гэж дуудах..."
"Ерөөлч, тэнэг хоёр сүйд боллоо" гэлцээд
Есөн булгийн хяраас арай гэж олтол
Өмссөн хүрмээ цэцэн Самбууд нөмөргөөд
Өчүүхэн хүүхэд шиг элгэндээ түүнийг тэврээд
Өршөөлд нь, ерөөлч дөнгөж голтой үлдсэн юм
Өнөөх тэнэг чинь амь алдсан байсан юм
"Ерөөлчийг авраад, өөрөө үхжээ" гэхэд
Ёроолгүй тэнэг хүн ээ гэж ухаантнууд аанай л шоолсон юм" [Цоодол, 2008. Х. 304] гэж сайхан сэтгэлтэй, хар буруу санаагүй, тусч нэгний тухай Д. Цоодол өгүүлээд, ерөөс хүний мөн чанарт оршиж байдаг аливаа зүйлийн нүдэнд өртөж буй өнгөн тал буюу хэлбэрт анхаарч тэдгээрийн дотоод мөн чанарыг умартдаг явдлыг уран сайхны аргаар илэрхийлсэн юм. Эл дуулийн тухай судлаач Д. Цэвээндорж *"Өрөөлийг хайрлаж чадалгүй тэнэгээр нь дуудсаар өөрсдөө эмгэнэлт байдалд тулж очиж буй "Тэнэг" дуульд бусдыг авраад өөрөө үхэхэд нь хүртэл "ёроолгүй тэнэг хүн ээ" хэмээн шагширсаар хоцрох нь хүний жинхэнэ мөн чанарыг ойлгож чадалгүй байсаар эцэст нь ухаарч буй нийгмийн эмгэнэлт цаг үеийг шүүмжлэн сэтгэж чадсаныг харуулдаг"* [Цэвээндорж, 2009. Х. 191] гэж дүгнэсэн байдаг. Тус дуулийн гол баатар өөрийгөө умартан бусдын сайн сайхны төлөө бүхнээ зориулж буй нигүүлсэнгүй сэтгэл нь монгол хүний уугуул мөн чанарыг илтгэх үнэт зүйл юм.

Д. Цоодолын хүүрнэл зохиолын туурвил зүйн онцлог

Д. Цоодол нь хүүрнэл зохиолын төрлөөр "Хонины боол" (2008), "Хөеө" (2011), "Нулимс холоос харагдахгүй" (2013), "Дуулж дуусдаггүй орчлон" (2015), "Талынбулагийн вант улс" (2018), "Ганзагалаа" (2019), "Хамаатан" (2024) зэрэг ном хэвлүүлсэн байна. Эдгээр нь хүүрнэл зохиолын өгүүллэг, эсээ, туурь, нэхэн дурсахуй, ойлбор, дурсамж, ёгтлол, егөөдөл, сэтгүүл зүйн нийтлэл зэрэг олон зүйлд хамаарах юм. Түүний хүүрнэл зохиолын зүйлчлэлийн талаар До. Цэнджав өгүүлэхдээ Д. Цоодол нь "*бүтээхүйн урын сандаа жижиг жижиг тэсрэлт үүсгэсэн уран гойд бичил зүйлчлэлийг бий болгохдоо "уран зохиолыг сэтгүүлжүүлж, сэтгүүл зүйг уран зохиолжуулах" шинэчлэл хийжээ гэж үзэж болохоор байна*" [Цоодол, 2019. Х. 266] хэмээжээ.

Д. Цоодолын хүүрнэл зохиолд дурсамж чухал байр суурьтай бөгөөд түүний хүүрнэх арга барил нь дурсахуй гэж хэлж болно. Д. Цоодолын хүүрнэл зохиолын бусдаас ялгарах ур чадвар, онцлог шинж нь амьд ахуйлаг орчин, амьд хүүрнэл, амьд дүр, амьд үг хэллэг, амьд хөдөлгөөн, амьд барим тавим үйл юм. Түүний зохиолуудыг уншиж байхад барагтай бол хүний нүдэнд өртөхөөргүй нуугдмал зүйлийг нээж хэн бүхэн олж харах аргагүй ер бусын шинжийг нь олж бичдэг байна. Ялангуяа эсээнийх нь номыг уншиж байхад жирийн амьдрал дотроос ер бусын шинж чанартай зүйлийг ялган олж бичих гэдэг сониуч гэмээр зан нь тодхон харагдана.

Түүний хүүрнэл зохиолуудын сэдэв бол монгол нутаг, хөдөө тал, хөдсөн дээлт хөх өвгөд,

мал сүрэг, малчин ард юм. Мөн монгол хүний мөс жудаг, мөн чанар, нинж сэтгэл юм. Өөрөөр хэлбэл, нүүдэлчдийн сэтгэлгээг эх хэлээр нь дамжуулан уран дүрслэл бүтээж зохиолынхоо санааг нээдэг уран бүтээлч бол Д. Цоодол юм.

"Нулимс холоос харагдахгүй", "Зугаатай өдөр", "Угаасан эсгий малгай", "Навтарга" гэзд л бараг бүх зохиолоос нь монгол хүний үнэнч шударгуу чигч шулуун зан, энэрэл хайр, эх нутаг, элгэн саднаа гэсэн мах цусанд шингэсэн уугуул бодол сэтгэл, бэрхшээлийн өмнө сөхөрч сөгддөггүй ясны хатуу чанар, монгол хүний холч, голч ухаан харагддаг. Түүнийхээ хажуугаар амьдралыг шорвог гашуун болгож буй бусармаг явдал, буруу тэрслүү хүмүүсийн үг үйлдлийг ч уншигчдад эгдүүцэл, зэвүүцэл төрүүлэхээр дүрслэн бичсэн байдаг. Үйл явдлын олон зөрчил бий болгох гэхээсээ илүү тухайн хүний мэдрэмж рүү хандсан, үг бүрээр нь уншиж байж ойлгох, мэдрэх шинж Д. Цоодолын хүүрнэл зохиолуудад агуулагдсан байдаг.

Зохиолчийн хүүрнэл зохиолын дүрслэлүүд нь нэн өвөрмөц нарийн чимхлүүр байдаг. Тэр бээр зохиолууддаа ямар нэгэн жижиг зүйл (эд юмс, хөндлөнгийн хүн, мал амьтан, ургамал гэх мэт)-ийг дүрсэлдэг бөгөөд тэрхүү жижиг зүйлийн дүрслэлээр зохиолынхоо дүрүүдийн дотоод сэтгэлийг нээдэг онцлогтой. Тодруулбал, "Хонгор Намнан" өгүүллэгт: "*Гэрийн баруун хаяанаас сойсон аарцны хүүдийнээс шар сүү хаяа нэг дуслах, хоймрын авдар дээрх хөлтэй орос цаг түг түг цохилохоос өөр чимээ анирГүй. Хаяагаар орох салхиар агь, саяхны бороонд сэргэсэн ногооны үнэр сулхан ханхалж, үл мэдэг сэрүү татах нь аятайхан. Тооноор харан хэвтэхэд тэртээ дээр хөх тэнгэр, өнгө өнгийн үүл нэг л мэдэхэд байрандаа үгүй болж, оронд нь бас нэгэн үүл гараад ирчихсэн байна. Эсвэл тэнгэр улам хол, улам хөх өнгөтэй болж, тэнд нэгэн бараан шувуу элэн халин эргэлдэн ниснэ*" [Цоодол, 2015. Х. 265] гэхчлэн дүрслэн бичжээ. Иймэрхүү чимхлүүр дүрслэлээр зохиолч баатруудынхаа дотоод сэтгэлийг илэрхийлдэг онцлогтой. Энэ мэт жишээ олныг дурдаж болно. Түүнчлэн түүний хүүрнэл зохиолууд бүхэлдээ хошин шог, егөөдөл, паян, инээд наргиа, дүрсгүйтэл, хөгтэй явдал, хошигнолоор дүүрэн байдаг онцлогтой. Д. Цоодолын хүүрнэл зохиолд уянгын гүн сэтгэлгээтэй хамт хошин шог, егөө хүчтэй илэрдэг. Тэрээр аливаа нийгмийн сөрөг үзэгдэл, хүний сул тал, алдаа завхралыг шоглон элэглэж, уншигчийг инээлгэх атлаа нухацтай ухааралд хүргэдэг. Энэ нь түүний зохиолуудыг амь оруулан хөдөлгөөнд оруулдаг өвөрмөц онцлог нь юм.

Түүнчлэн түүний уран бүтээлийн өвд оруулгын бүтээлүүд чухал байр эзэлнэ. Тэр бээр орчуулагчийн хувьд В. П. Смирновын "Хэвлэлийг намаас удирдах ленинч зарчим" (1988) (Б. Пүрэвдаштай хамтран орчуулсан), Константин Паустовский "Сүйх тэргээр аялсан шөнө" (2008), "Ярьдаг тэмээ буюу хойт айлуудын үлгэрүүд" (2008), Акутагава Рюноскэ "Ид шидийн урлаг" (2009), А. П. Чеховын "Бачтай хүмүүс" (2011), Ги Де Мопассаны "Сураггүй бологч" (2012), Марти Ларнигийн хүүрнэл зохиолууд "Мөнхийн бор өдрүүд" (2013), Михайл Пришвин "Мөнхийн гутал", Альфонс Доде "Алтан тархит хүмүүний домог" (2021) зэрэг олон зохиолыг монгол хэлэнд орчуулсан байна. Түүнчлэн Рабиндранат Таагүр, Эрнест Хэмингуэй, И. А. Бунин, Ф. М. Достоевский, А. А. Платонов, Василий Шукшин, Трибор Дери зэрэг зохиолчдын өгүүллэг, Максим Танк, Федерико Лорка нарын шүлгүүдийг монгол хэлнээ яруу тансаг оруулжээ. Орчуулгынх нь онцлогийн талаар судлаач Б. Ганбат "*Д. Цоодол уран сайхны орчуулгын ажилд авьяас билгээ зориулсаар ирэв. Түүний орчуулга 1980-аад оны дунд үеэр гарч эхэлсэн гэж бодохоор туулсан хугацаа туурвин бүтээсэн аль аль нь их юм. Андрей Платонов, Константин Паустовский болон Япон, Америк, Энэтхэг, Молдав, Дани, Армен, Гүрж, Унгар зэрэг олон орны зохиолчдын бүтээлээс монголчууддаа орчуулан хүргэж байна. Их зохиолч А. П. Чеховын шилдэг өгүүллэгүүдийг орчуулан томоохон ном болгож "Хөөрхий хонгор минь" нэртэйгээр хэвлүүлснийг үзвэл тун уншуурТай, яруу сайхан орчуулга болов. Уран сайхны орчуулга бол бие даасан уран бүтээл мөн*" [Цоодол, 2019. Х. 260] хэмээсэн бол Д. Цэнджав "*Сүүлийн үеэс орчуулгаар гангарах боллоо. Чехов, Акутагава, Паустовский, Мопассан, Омар Хаям гэзд хамгийн сонгодгоос нь, хамгийн төвөгтэйг нь барьж авна. Хэдийдээ амжуулдаг юм бэ гэмээр хэцүү үг хэллэгтэй,*

хүнд далд санаатай олон олон ном орчуулав аа. Монгол хэл хэллэг, ахуй амьдралтай нь яв цав дүйцүүлэн уусгаж чаддаг. Юм юмтай зуурал даж, чангаалдаж байна гэдэг яруу найрагч хүн өөрөө өөрийгөө эвдэж, шинээр төрөхөд юунаас ч тустаа зүйл. Цаг хугацаа өнгөрөх тусам А. П. Чехов руу хошуурцгааж, орос хэлний гайхамшиг, орос хүний дотор сэтгэлийг мэдэрч байх юм. Баргийн юм тоодоггүй америкчууд Чеховын бүтээлийг жил бүр шахуу орчуулж хэвлэсээр байдгийг би биеэрээ үзэж мэдсэн. Түүний орчуулгын ур чадварыг судлах цаг ирнэ. Ингээд Дөнгөтийн Цоодол яруу найраг, сэтгүүл зүй, орчуулга гээд миний мэдэхээс гурвалсан сайхан морьдтойгоо энэ өвлийн их цасан дундуур дүүхэлзэн давхиж явна [Цоодол, 2019. Х. 276] хэмээн үнэлсэн байна.

Д. Цоодол нь өөрийн гэсэн туурвил зүйн арга барил, өвийг бүтээсэн монголын орчин үеийн уран зохиолын томоохон төлөөлөгч билээ. Түүний сэтгүүл зүй болоод орчуулгын ажлууд нь хүүрнэл зохиол бичихэд нь дөхөм зам болсон байх бөгөөд тэр бээр дурсамж хэлбэрээр зохиол бүтээлээ хүүрнэн өгүүлж, төрсөн нутгийнхаа зон олны ахуй амьдралыг тод томруун дүрсэлж, монгол хүний нинж сэтгэлийг дэлгэн үзүүлдэг онцлог шинжүүд харагдаж байна.

Д. Цоодолын шүлэг найраг дорно дахины тэр дотроо монгол яруу найргийн уламжлал, тансаг бичлэгтэй, ардын аман зохиолын гарвальтай бөгөөд сэтгэлгээний хувьд дорно, өрнийхийг эвцэлдүүлсэн шинжтэй байна. Түүний шүлгийн мөрүүд хэм тэгш зарчимтай тул үгс төгс зохицолтой, уянгалаг сонсголонтой байна. Цэц, уянга хийгээд бодол эргэцүүлэл, бясалгалын үр болсон гүн ухаан гурав нийлэн зохицсон нь Д. Цоодолын шүлэг найргийнх үндсэн онцлог мөн. Монголын орчин үеийн яруу найрагт олон шилдэг уран сайхны дүр бүтээн туурвисан нь манай яруу найрагт оруулсан томоохон хувь нэмэр болжээ. Тэрбээр яруу найргийн туурвил зүй, төрөл зүйлийн хөгжил, өгүүлэмжид олон нээлт хийсэн байна.

Хүүрнэл зохиол болоод дуулиудаас нь Бүрэн сумынхны амьдрал, ахуй байдал, хүн ардын жаргал зовлон, хэв заншил тод харагддаг. Д. Цоодолын хүүрнэл зохиолд дурсамж чухал байр суурьтай бөгөөд түүний хүүрнэх арга барил нь дурсахуй гэж хэлж болно.

Ашигласан ном зүй

Галбаатар, 1994: *Галбаатар Д.* Монгол дууль. Улаанбаатар, 1994.

Галбаяр, 2017: *Галбаяр Г.* Монгол шүлэг дэх задгай буюу чөлөөт хэмжээт шүлгийн зүй тогтол. Токио, 2017.

Ганбат, 2019: *Ганбат Б.* Утга зохиолын шүүмжлэл, судлал / Ред. Ш. Цэнд-Аюуш. Улаанбаатар: "Мөнхийн үсэг" ХХК, 2019.

МОҮУЗТ 2014: Монголын орчин үеийн уран зохиолын түүх-IV. (ШУА, ХЗХ). Улаанбаатар, 2014.

Нэргүй, 2021: *Нэргүй Ж.* Юуны учир Цоодол Абугай орчуулга хийдэг вэ? Д. Цоодолын орчуулсан Альфонс Доде "Алтан тархит хүмүүний домог" номын өмнөх үг. Улаанбаатар, 2021.

Сумъяа, 2009: *Сумъяа Д.* Монголын орчин үеийн яруу найраг. Улаанбаатар: "Жиком" пресс, 2009.

Цоодол, 2008: *Цоодол Д.* Сарваа цуцахын талаас. Улаанбаатар: "Жиком" пресс, 2008.

Цоодол, 2008: *Цоодол Д.* Хонины боол. Улаанбаатар: "Жиком пресс" ХХК, 2008.

Цоодол, 2015: *Цоодол Д.* Дуулж дуусдаггүй орчлон. Улаанбаатар: "Мөнхийн үсэг" ХХК, 2015.

Цоодол, 2018: *Цоодол Д.* 2018. Талынбулагийн вант улс. Улаанбаатар: "Сэлэнгэ пресс" ХХК, 2018.

Цоодол, 2019: *Цоодол Д.* Ганзагалаа. Улаанбаатар, 2019.

Цэвээндорж, 2009: *Цэвээндорж Д.* Сэтгэн сэтгэж бичихийн үлгэр болох Дөнгөтийн Цоодолын дууль найраглалын эрэл олз. Улаанбаатар: "Эрэн цагийн шүүмж", 2009.

THE ARTISTIC HERITAGE AND STYLISTIC FEATURES OF D. TSOODOL'S WORKS

Batmunkh Munkh-Erdene
Institute of Language and Literature of the Mongolian Academy of Sciences

The State Honored Writer and Honored Worker of Culture of Mongolia D. Tsoodol (born 1944) is one of the most prominent representatives of contemporary Mongolian literature. The article deals with some features of the D. Tsoodol's poetics. Such aspects of his writing method as structure of his poems, process of creation, regularities of his artistic manner and lyrical thinking are analyzed. The article also deals with the features of D. Tsoodol's narrative writings and aims to highlight their distinctive features and characteristics. For that purpose the environment is examined in which D. Tsoodol's works came to life and which shaped his narrative style. D. Tsoodol is a major representative of modern Mongolian literature who has created his own style and legacy. His work as a journalist and translator must have determined a favorable path for him as a writer. He creates his works in the form of memoirs, vividly portrays the daily life of the people of his homeland, and reveals the mentality of the Mongols. The lifestyle, circumstances, joy, pain and morals of the Mongols, especially of dwellers of Buren sum, are clearly shown in his prosaic works and ballads. Memory plays an important part in D. Tsoodol's creative work, and his narrative style can be described as memorial.

Key words: Tsoodol, contemporary Mongolian writers, modern Mongolian poetry, narrative prose, modern Mongolian literature.

About the author: **Batmunkh Munkh-Erdene**, Researcher of the Literary Studies Section, Institute of Language and Literature of the Mongolian Academy of Sciences (Ulaanbaatar, Mongolia) (munkherdene_b@mas.ac.mn).

ХУДОЖЕСТВЕННОЕ НАСЛЕДИЕ И СТИЛИСТИЧЕСКИЕ ОСОБЕННОСТИ ПРОИЗВЕДЕНИЙ Д. ЦООДОЛА

Б. Мунх-Эрдэнэ
Институт языка и литературы Монгольской академии наук

В статье рассматривается творческое наследие и поэтика одного из крупнейших представителей современной монгольской литературы, народного писателя Монголии, лауреата Государственной премии, заслуженного деятеля культуры Д. Цоодола (род. 1944). Цель данной статьи — выявить индивидуальные особенности поэтики и повествовательного стиля Д. Цоодола, определить специфику его художественной манеры, а также охарактеризовать культурно-литературную среду, в которой формировалось и реализовывалось его творчество. Д. Цоодол — универсальный мастер художественного слова, плодотворно работавший практически во всех жанрах литературы: в поэзии, прозе, переводе, публицистике и эссеистике. Его творчество отличается глубоким постижением красоты и духовных основ традиционного монгольского быта, гармоническим осмыслением связи человека и природы, философской рефлексией над внутренним миром личности. Художественные образы писателя раскрывают эстетическую утонченность и оригинальность мировосприятия, обогащая монгольскую словесность новыми формами художественного выражения. Особое место в литературном наследии Д. Цоодола занимает жанр *дуули* (лироэпическая поэма), к развитию которого он внёс значительный вклад, расширив тематические и поэтические горизонты современной монгольской литературы. Автор сосредотачивает внимание на своеобразии художественного метода писателя, особенностях структуры и жанровой специфике его поэзии, вкладе в развитие жанра *дуули* а также на некоторых характеристиках его повествовательной прозы.

Ключевые слова: Цоодол, современные монгольские писатели, современная монгольская поэзия, повествовательная проза, современная монгольская литература.

Об авторе: **Батмунх Мунх-Эрдэнэ**, научный сотрудник сектора литературоведения, Институт языка и литературы Монгольской академии наук (Монголия, Улан-Батор) (munkherdene_b@mas.ac.mn).